



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 00
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ УС ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ОНӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БҮҮВЭЙБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах 2024 оны худалдан авах бараа материал, ажил үйлчилгээний төлөвлөгөөг 3,459,880.5 мянган төгрөгөөр баталж, төлөөлөн удирдах зөвлөлийн 2 удаагийн тогтоолоор 275,819.2 мянган төгрөгөөр өсгөн тодотгож баталсан байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 30,990.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 32,605.5 сая төгрөгөөр, 1,615.3 сая төгрөгийн алдалдалтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 31,902.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 32,737.5 сая төгрөгийн зардал гарган 68.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлыг төлөвлөснөөс 1,547.0 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

Тайлант онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 4,243.1 мян.м³ ус хүлээн авч, 2,300.1 мян.м³-ийг борлуулж, 1,179,2 мян.м³ усыг орлого болоогүй усны өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилт, 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг дээд шатны захирагч дүгнээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА